



**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОТ  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY**



**ШУТИС-203**   
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Улаанбаатар хот  
2020**



## ӨМНӨХ ҮГ

Монгол улсын Шинжлэх ухаан, технологийн их сургууль өнгөрсөн түүхт 60 жилийн хугацаанд улс эх орны их бүтээн байгуулалт, аж үйлдвэрийн салбаруудыг бэхжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж, шинжлэх ухаан, технологи, эдийн засаг, нийгэм хүмүүнлэг, бизнесийн салбаруудыг хөгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулсаар ирсэн билээ.

Асар хурдтай хувьсан өөрчлөгдөж байгаа өнөөгийн нийгэмд боловсролын зорилго, хүртээмж, чанарын асуудлыг шинээр тодорхойлон авч үзэх шаардлага дэлхийн улс орнуудын өмнө эн тэргүүнд тавигдаж байна.

Орчин үеийн тэргүүлэх их сургуулиуд XXI зуунд зөвхөн шинэ мэдлэгийг буй болгогч, түгээн дэлгэрүүлэгч байгаад зогсохгүй улс орныхоо болон дэлхийн эдийн засгийн гол хөдөлгөгч хүч, инновацийн эх булаг болох талаар хөгжлийн эрхэм зорилгоо тодорхойлдог болжээ.

Нөгөө талаас Монгол улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Инновацийн тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024), Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого, Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого, Судалгаанд суурилсан их сургууль хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Үр дүнд суурилсан боловсролынт огтолцоог хөгжүүлэх төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдтэй уялдуулан ШУТИС-ийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, стратегийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн тодорхойлох хэрэгцээ шаардлага тулгарч байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 2.2.3-ын зорилт 5-д “Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ” гэж заасан байна.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024) баримт бичгийн 7.13-т “Монгол Улсын дөрвөөс доошгүй их сургуулийг Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд хүргэсэн байна” гэсэн зорилтыг дэвшүүлжээ.

Эдгээр зорилтууд нь улс орны ирээдүйн хөгжилд ШУТИС-ийн гүйцэтгэх үүрэг, мөн тус их сургуулийн цаашдын хөгжлийн зорилго, зорилтуудыг үндсэнд нь тодорхойлсон гэж үзэж болно. Иймд өнөөгийн сургалтад суурилсан тогтолцооноос орчин үеийн судалгаанд суурилсан их сургуулийн түвшинд аажмаар амжилттай шилжиж, дэлхийн шилдэг их сургуулийн нэг болж эх орныхоо хөгжлийн бодит хөдөлгөгч хүч байхыг ШУТИС зорьж, тэмүүлж байна.

Энэ өөрчлөлтийг бид сайн засаглалыг бэхжүүлж, хамт олны гишүүн бүрийн мэдлэг, ур чадвар, бүтээлч сэтгэлгээ, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар нэгдмэл зорилготойгоор хэрэгжүүлэх нь гарцаагүй юм. Нөгөө талаас төрийн тууштай дэмжлэг шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд төр-их сургууль-бизнесийн салбарын гурвалсан холбоо, хамтын нэгдмэл үйл ажиллагаа бидний хөгжлийн нэг чухал түлхүүр болно.

ШУТИС-2030 хөгжлийн стратеги төлөвлөгөөг нийт оролцогч талуудын оролцоонд тулгуурлан 2030 онд дэлхийн шилдэг 1000 сургуулийн эгнээнд багтаж, дэлхийн жишигт нийцсэн их сургууль болон хөгжих, улмаар ирээдүйн хөгжилд төр, бизнесийн байгууллагуудын өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэгч нь байх үүрэгтэйгээр оролцох зорилго тавин боловсруулж та бүхэнд өргөн барьж байна.

ШУТИС-ийн Удирдах  
зөвлөлийн дарга

Д.Бадарч

ШУТИС-ийн Захирал

Б.Очирбат



## АЛСЫН ХАРАА:

ДЭЛХИЙД ҮНЭЛЭГДЭХ  
ОЮУНЫ ҮНЭ ЦЭНИЙГ БҮТЭЭНЭ



## ЭРХЭМ ЗОРИЛГО:

ЭХ ОРНЫ ХӨГЖЛИЙН ГАРЦЫГ  
ТОДОРХОЙЛОХ ХҮН-БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН МЭДЛЭГ,  
ИННОВАЦИЙГ БҮТЭЭХ  
АВЬЯАС ЧАДВАРЫН ТӨВЛӨРӨЛ БАЙНА.



 УРИА:

“ АСУУДЛЫГ БҮТЭЭЛЧЭЭР  
ШИЙДЬЕ!  
”

УРТ ХУГАЦААНЫ  
ҮНДСЭН ЗОРИЛГО:

2030 онд дэлхийн  
шилдэг 1000 их  
сургуулийн нэг болно.






ШУТИС-ИЙН ХАМТ ОЛОН (ПРОФЕССОР БАГШ,  
СУДЛААЧ, АЖИЛТАН, СУРАЛЦАГЧ, ТӨГСӨГЧ) БИД ЭРХЭМ ЗОРИЛГОО  
БИЕЛҮҮЛЭХИЙН ТУЛД ДАРААХ ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ БАРИМТЛАН,  
ДАГАЖ МӨРДӨНӨ.







ШИЛДЭГ  
ГҮЙЦЭТГЭЛ  
EXCELLENCE



УЛАМЖЛАЛ  
TRADITION



ТЭМҮҮЛЭЛ  
INSPIRATION



ИННОВАЦИ  
INNOVATION



САЙН-  
ХҮМҮҮНЛЭГ  
ЗАСАГЛАЛ  
HUMANE  
GOVERNANCE

Ш

## ШИЛДЭГ ГҮЙЦЭТГЭЛ

EXCELLENCE

Бид бүтээлч сэтгэлгээ, ур чадварт тулгуурлан тогтсон стандартаас давсан үр дүнгээр манлайлагч байна.

У

## УЛАМЖЛАЛ

TRADITION

Бид өнгөрсөн, одоо, ирээдүйн залгамж холбоог дээдэлсэн, шинэчлэлийг эрэлхийлэгч байна.

Т

## ТЭМҮҮЛЭЛ

INSPIRATION

Бид эрхэм зорилгоо биелүүлэхийн төлөө тасралтгүй тэмүүлэгч байна.

И

## ИННОВАЦИ

INNOVATION

Бид шинийг санаачлагч, оюуны бүтээлийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэгч, энтрепренер байна.

С

## САЙН-ХҮМҮҮНЛЭГ ЗАСАГЛАЛ

HUMANE GOVERNANCE

Бид аливаад хүмүүнлэг энэрэнгүй сэтгэлээр хандаж, сайн засаглалын зарчмыг баримтална.



# СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

01

СУРАЛЦАХУЙН  
ШИНЭЧЛЭЛ БА  
КАРЬЕР ХӨГЖИЛ

02

СУДАЛГААНЫ  
ТӨГӨЛДӨРШИЛ

03

ИННОВАЦИ,  
ТЕХНОЛОГИ  
АРИЛЖААЛАЛ

04

НИЙГМИЙН  
ХАРИУЦЛАГА

05

ЗАСАГЛАЛ,  
МЕНЕЖМЕНТИЙН  
ШИНЭЧЛЭЛ





## ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ –1: СУРАЛЦАХУЙН ШИНЭЧЛЭЛ БА КАРЬЕР ХӨГЖИЛ

**Зорилго:** Хүнлэг, энэрэнгүй, бүтээлч сэтгэлгээтэй шинэ үеийн инженер, манлайлагчдыг бэлтгэнэ.

№	Зорилтууд	Хэрэгжүүлэх стратеги	Явцын хэмжих үзүүлэлт
1.1	Боловсролын чанарт тулгуурласан судалгаа, сургалтын орчин, дэд бүтцийг бүрдүүлнэ.	<ol style="list-style-type: none"><li>Сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг хүртээмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангана.</li><li>Орчин үеийн сургалтын лабораториудыг байгуулна.</li><li>Номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмж, менежментийг сайжруулж дэлхийн жишигт нийцүүлнэ.</li><li>Олон улсын жишигт хүрсэн спортын байр, танхимтай болно.</li><li>Тусгай боловсролын хэрэгцээг хангах орчныг бүрдүүлнэ.</li></ol>	<ul style="list-style-type: none"><li>Сургалтын орчин, дэд бүтцийн талаар сэтгэл ханамж (суралцагч + асран хамгаалагч),</li><li>Номын сангийн хөрөнгө оруулалт (нийт орлогын 1%),</li><li>Нэг оюутанд ногдох номын төрөл, ангилал,</li><li>Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулагдсан орчин (нийт талбайд эзлэх хувь)</li></ul>
1.2	Авьяастай элсэгчдийг татан төвлөрүүлнэ.	<ol style="list-style-type: none"><li>Дотоод, гадаадын шилдэг сурагч, оюутныг татах, суралцуулах нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчныг бий болгож тэтгэлэг хэлбэрээр төрийн дэмжлэг авна.</li><li>Санхүүжилтийн олон талт эх үүсвэр бүхий академик тэтгэлгийн хөтөлбөрүүдийг бий болгож, олон улсын шилдэг чадварлаг суралцагчдыг татна.</li></ol>	<ul style="list-style-type: none"><li>Элсэлтийн хувь,</li><li>Элсэгчдийн босго онооны өсөлт,</li><li>Гадаад оюутны эзлэх хувь,</li><li>Тэтгэлэг хүртсэн суралцагчдын нийт суралцагчдад эзлэх хувь</li></ul>

		<p>3. Шинэ элсэгчдийн дасан зохицох, идэвхжих үйл ажиллагааг дэмжсэн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлнэ.</p> <p>4. Туслах багшаар чадварлаг магистр, доктор оюутныг ажиллуулна.</p>	
<p>1.3</p>	<p>Сургалтын үйл ажиллагаанд инновац нэвтрүүлнэ.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн ур чадварын эрэлт хэрэгцээ, ирээдүйн чиг хандлагад уялдуулан хөтөлбөрийг шинэчилж хэрэгжүүлдэг, уян хатан тогтолцоог хөгжүүлнэ.</li> <li>2. Хөтөлбөрүүдийг олон улсад магадлан итгэмжлүүлнэ.</li> <li>3. Ахисан түвшний сургалтыг чанаржуулж, дийлэнх хөтөлбөрийг англи хэл дээр явуулна.</li> <li>4. Элсэгч, суралцагч, байгууллагуудад сургалтын уян хатан хэлбэр (хугацаа, төлбөр гэх мэт)-үүдийг санал болгоно.</li> <li>5. Аж үйлдвэрийн IV хувьсгалын эринд ажиллах мэргэжилтнүүд (Зүйлсийн интернэт (IoT), Хөдөлгөөнт төхөөрөмжүүд (Mobile equipments), Үүлэн технологи (Cloud), Их өгөгдөл (Big data), Блокчэйн (Blockchain) чиглэлийн)-ийг бэлтгэнэ.</li> <li>6. Суралцагчдын англи хэлний чадварыг сайжруулж, түвшинг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх шалгалтын оноогоор үнэлнэ.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөтөлбөрийг сонгосон элсэлтийн хувь,</li> <li>• Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь,</li> <li>• Төгсөлтийн хувь (анх элсэн орсон хувь хэмжээгээр болон төгсөөгүй оюутнаар),</li> <li>• Ахисан түвшний төгсөгчдийн хувь,</li> <li>• Англи хэл дээр явах ахисан түвшний хөтөлбөрийн хувь,</li> <li>• Олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн нийт хөтөлбөрт эзлэх хувь,</li> <li>• Гадны их сургуультай хамтарсан сургалтын хөтөлбөрийн тооны нийт хөтөлбөрт эзлэх хувь,</li> <li>• Гадаадын их сургуультай хамтарсан ахисан түвшний хөтөлбөрийн тоо,</li> <li>• Дотоод/гадаадын их сургууль руу илгээсэн/ирсэн нэг суралцагчид ногдох кредитийн тоо,</li> <li>• IELTS, TOEFL, TOE-IC шалгалт өгсөн суралцагчийн хувь</li> </ul>



1.4	Судалгаа болон үр дүнд суурилсан сургалтыг эрчим-жүүлнэ.	<ol style="list-style-type: none"> <li>1. Цахим сургалт, хосолсон сургалт (blended learning), нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээл (МООС) зэрэг дэвшилтэт арга технологийг ашиглаж, курс хичээлүүдийг шинэчилж, хөгжүүлнэ.</li> <li>2. Бүтээлч сэтгэлгээ, зөөлөн ур чадварыг хөгжүүлэх, энтрепренёршип боловсрол олгох хичээлүүдийг хөтөлбөрт тусгана.</li> <li>3. Сургалтын улирал, багц цагийг дэлхийн шилдэг их сургуулийн жишигт нийцүүлэн өөрчилнө.</li> <li>4. Карьер хөгжлийн төв байгуулж, суралцагчдын Карьер хөгжлийн хөтөлбөр боловсруулна.</li> <li>5. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш, суралцагчийн тооны харьцаа,</li> <li>• Дижитал сургалтын багш, суралцагчийн харьцаа,</li> <li>• Суралцагчдын идэвх, оролцоо,</li> <li>• Суралцагчийн голч дүн,</li> <li>• Сургалтын сэтгэл ханамжийн түвшин,</li> <li>• Цахим, онлайн сургалтын тоо</li> </ul>
1.5	Багш, судлаачийг өөрийгөө тасралтгүй хөгжүүлэхэд дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.	<ol style="list-style-type: none"> <li>1. Сургалтын шинэ дэвшилтэт арга, технологи, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр санал болгоно.</li> <li>2. Багш, судлаачийн англи хэлний чадварыг сайжруулж, түвшинг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх шалгалтын оноогоор үнэлнэ.</li> <li>3. Англи хэл дээр ахисан түвшний хөтөлбөр явуулах профессор багшийг дэмжинэ.</li> <li>4. Залуу багш судлаачдын практик дадлага туршлагыг аутсорсинг (outsourcing) хэлбэрээр хөгжүүлнэ.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь,</li> <li>• Багшийн хөгжилд зориулсан санхүүжилтийн хэмжээ,</li> <li>• Тэргүүлэх 300 сургуульд доктор хамгаалсан багшийн тоо,</li> <li>• IELTS, TOEFL, TOE-IC шалгалт өгсөн багшийн эзлэх хувь</li> </ul>



## ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ – 2: СУДАЛГААНЫ ТӨГӨЛДӨРШИЛ

**Зорилго:** Монгол улс, олон улсын хэмжээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхүйц судалгааг хөгжүүлнэ.

№	Зорилтууд	Хэрэгжүүлэх стратеги	Явцын хэмжих үзүүлэлт
2.1	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтдийн төвлөрлийг бий болгох, залуу эрдэмтэн, судлаачдыг хөгжүүлнэ.	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш судлаачдыг сонгон шалгаруулах систем нэвтрүүлэх (тенюр), олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэд (докторын дараах болон ахисан түвшний судлаач)-ийг татах, тогтвортой ажиллуулахад төрийн дэмжлэг авна.</li> <li>2. Багш, судлаачидтай судалгааны ажлын үр дүнгийн гэрээ байгуулна.</li> <li>3. Багш, судлаачдын ажлын үнэлгээ, урамшууллын системийг сайжруулна.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш судлаачдын сэтгэл ханамжийн үнэлгээ,</li> <li>• Дэлхийн их сургуулийн зэрэглэлийн судалгаанд нэр дурдагдсан багш судлаач,</li> <li>• Докторын дараах хөтөлбөрт хамрагдсан судлаачийн тоо,</li> <li>• Гадаад багшийн нийт үндсэн багшид эзлэх хувь,</li> <li>• Судалгаа, шинжилгээ, төслийн ажил гүйцэтгэсэн судлаачийн нийт багшид эзлэх хувь</li> </ul>
2.2	Дэлхийн шилдэг их сургуулийн жишигт нийцүүлэн судалгааны тохиромжтой орчин бүрдүүлнэ.	<ol style="list-style-type: none"> <li>1. Үндэсний болон олон улсын түвшинд магадлан итгэмжлэгдсэн салбар дундын судалгааны төв, хүрээлэн, лабораториудыг хөгжүүлж, ашиглалт, хамтын ажиллагааг дээшлүүлнэ.</li> <li>2. Судалгааны санхүүжилтийн эх үүсвэрийг Төрөөс баримтлах бодлогод тусгасны дагуу төрийн мөн хувийн хэвшлийн оролцоотойгоор бүрдүүлнэ.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Нээлттэй, салбар дундын, магадлан итгэмжлэгдсэн лабораторийн тоо,</li> <li>• Судалгааны санхүүжилт (грант)-ын өсөлт,</li> <li>• Олон улсын болон үндэсний хэмжээний судалгааны грант авсан багш нарын үндсэн багшид эзлэх хувь</li> </ul>



2.2	Дэлхийн шилдэг их сургуулийн жишигт нийцүүлэн судалгааны тохиромжтой орчин бүрдүүлнэ.	<ol style="list-style-type: none"><li>3. Ахисан түвшний судалгааг олон улсын түвшинд (бүтэн цагаар судалгаа явуулах гэх мэт) зохион байгуулдаг соёлыг төлөвшүүлнэ.</li><li>4. Судалгаанд зарцуулах санхүүжилтийг тогтмол нэмэгдүүлж, багш судлаачдад судалгааны санхүүжилт (грант) олгоно.</li></ol>	
2.3	Улс орны хөгжлийн тулгамдсан асуудлаар салбар дундын шийдлийг бий болгож, нэвтрүүлнэ.	<ol style="list-style-type: none"><li>1. Судалгааны тэргүүлэх чиглэлүүдийг аж үйлдвэрийн 4-р хувьсгалын хэрэгцээнд нийцүүлэн тодорхойлж, нэгдмэл платформ хөгжүүлж, холбогдох судалгааг дэмжинэ.</li><li>2. Судалгааны хамтын ажиллагааг хөгжүүлж, захиалгат төслийг дэмжиж, нэмэгдүүлнэ.</li><li>3. Судалгааны ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээ, урамшууллын системийг нэвтрүүлж, судалгааны чанарыг сайжруулна.</li></ol>	<ul style="list-style-type: none"><li>• Олон улсын бүтээлийн санд (Scopus, web of science...) бүртгэгдсэн хамтарсан судалгааны бүтээл,</li><li>• Судлаачдын сэтгэл ханамжийн үнэлгээ,</li><li>• Грант хүртсэн судалгааны ажлын тоо,</li><li>• Нийт зардалд эрдэм шинжилгээний зардлын эзлэх хувь</li></ul>
2.4	Их сургуулийн оюуны өмчийн хадгалалт, хамгаалалтын механизмыг боловсронгуй болгож, судалгаа, бүтээлийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэнэ.	<ol style="list-style-type: none"><li>1. Оюуны өмчийн хамгаалалтын механизмыг цахим болгоно.</li><li>2. Бүтээлийн хуулбарлалт шалгадаг программыг үйл ажиллагаанд нэвтрүүлж ашиглана.</li></ol>	<ul style="list-style-type: none"><li>• Нэг багшид оногдох импакт фактор өндөртэй мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн тоо,</li><li>• Импакт фактор өндөртэй мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлээс нэг үндсэн багшид ногдох эшлэлийн тоо,</li></ul>

2.4	Их сургуулийн оюуны өмчийн хадгалалт, хамгаалалтын механизмыг боловсронгуй болгож, судалгаа, бүтээлийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэнэ.	<p>3. Эрдэм шинжилгээний бүтээл олон улсад хэвлүүлэх үйл явцыг идэвхжүүлж, эшлэлийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэж ШУТИС-ийн Цахим номын сангийн бүрдэл болгон хөгжүүлнэ.</p> <p>4. Олон улсад бүртгэлтэй сэтгүүлүүдийн хэвлэлтийн чанарыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрдэм шинжилгээний бүтээлийн сан хөмрөг,</li> <li>• Олон улсын бүртгэлийн сан (SCI)-д орсон эрдэм шинжилгээний сэтгүүлийн тоо,</li> <li>• Бүтээлийн хуулбарлалт шалгах программыг судалгааны үр дүн хэвлэлтэд ашигласан байдал,</li> <li>• Ном, сурах бичиг, өөрийн бүтээл, орчуулгын бүтээл, цахим хичээл, нээлттэй хичээлийн тоо</li> </ul>
-----	--	---	--



## ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ – 3: ИННОВАЦИ, ТЕХНОЛОГИ АРИЛЖААЛАЛТ

**Зорилго:** Технологи- үнэ цэнийг бүтээгч инновацийн кластер болон хөгжинө.

№	Зорилтууд	Хэрэгжүүлэх стратеги	Явцын хэмжих үзүүлэлт
3.1	Инновацийн соёл, энтрепренер сэтгэлгээг төлөвшүүлж, шилдэг инноваторуудыг төвлөрүүлнэ.	<ol style="list-style-type: none"><li>1. ШУТИС-ийн хэмжээнд инновацийн мэдлэг, ойлголтыг түгээх замаар оюуны өмчийг задлах, ашиглах, технологи дамжуулах арга зүй, соёл хандлагыг төлөвшүүлнэ.</li><li>2. Албан ёсны зөвшөөрөлтэй</li><li>3. (License) программ хангамжуудыг ашигладаг болно.</li><li>4. Профессор, багш судлаачдад энтрепренер боловсрол олгож, бизнес сэтгэлгээг нь хөгжүүлнэ.</li><li>5. Гадаадын чадварлаг энтрепренеруудыг урьж ажиллуулах, хамтарч судалгаа-инновац хийх тогтолцоо бүрдүүлнэ.</li></ol>	<ul style="list-style-type: none"><li>• ШУТИС-ийн эзэмшилтэй оюуны өмчийн тоо,</li><li>• Үндэсний болон олон улсад идэвхтэй патентын тоо,</li><li>• Гадаад багшийн нийт үндсэн багшид эзлэх хувийн жин</li></ul>

3.2	Инновацийн экосистемийг бүрдүүлнэ.	<ol style="list-style-type: none"> <li>1. Инновацийн үйл ажиллагааг тасралтгүй дэмжих (венч хөрөнгө оруулалтын сан) олон талт санхүүжилтийн эх үүсвэртэй болно</li> <li>2. Инновацид ээлтэй нэгжүүд (технологи дамжуулалт, инкубатор, хамтын оффис)-ийг байгуулна.</li> <li>3. Инновацийн хамтын ажиллагаа, /төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоод/ түншлэлийг хөгжүүлнэ.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Венч сангаас авсан санхүүжилтийн хэмжээ,</li> <li>• Бойжуулсан гарааны бизнесийн тоо,</li> <li>• Инновацийг дэмжих дэд бүтцийн нэгжийн тоо,</li> <li>• Хамтын ажиллагаатай байгууллагын тоо</li> </ul>
3.3	Оюуны бүтээлийг эргэлтэд оруулах замаар өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлчилгээ, инновацийг бий болгоно.	<ol style="list-style-type: none"> <li>1. Эдийн засгийн үр ашиг өгөх оюуны бүтээлийг худалдах, технологи дамжуулах, лицензийн гэрээ байгуулах замаар оюуны өмчид тулгуурласан гарааны компаниуд байгуулна.</li> <li>2. Гадаадын өндөр технологийг нутагшуулан улмаар мэдлэг шингээж, импортыг орлоход чиглэсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.</li> <li>3. Оюуны өмчийн роялти, лицензийн гэрээ, гарааны компанийн ногдол ашгаас олох орлогыг нэмэгдүүлнэ.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Лицензийн гэрээний тоо,</li> <li>• Бие даан гарсан компанийн тоо,</li> <li>• Үйлдвэрлэлд нэвтэрсэн технологийн тоо,</li> <li>• Оюуны өмчийн роялти орлогын хэмжээ</li> </ul>



## ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ – 4: НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

*Зорилго: Нийгмийн хариуцлагаа ухамсарласан манлайлагч их сургууль болно.*

№	Зорилтууд	Хэрэгжүүлэх стратеги	Явцын хэмжих үзүүлэлт
4.1	Иргэний боловсрол, шинжлэх ухааны соён гэгээрэлд хувь нэмэр оруулна.	<ol style="list-style-type: none"><li>ШУТИС-ийн нийгмийн хариуцлагын бодлогыг хэрэгжүүлж, иргэний боловсролыг дэмжих, шинжлэх ухаан, технологийн ололтыг нийтэд түгээх үйл ажиллагаа явуулна.</li><li>Нийгэмд ШУТИС-ийн нэр хүндийг өсгөх ажил, бүтээлийг дэмжинэ.</li><li>Тогтвортой хөгжил, байгаль орчинд ээлтэй ногоон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.</li><li>Сургуулиас гадуурх урлаг, соёл, соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг дэмжин, зохион байгуулна.</li></ol>	<ul style="list-style-type: none"><li>Нийгэм рүү чиглэсэн төсөл, хөтөлбөр, бүтээлч ажлын тоо</li><li>Суралцагчдын олон улсын эрдэм шинжилгээний хурал, уралдаан тэмцээнээс хүртсэн шагналын тоо</li><li>Нийт зардалд урлаг, соёл, соёлын өв хамгаалалтын зардлын эзлэх хувь</li></ul>
4.2	Эрх тэгш, хүртээмжтэй боловсролын үйлчилгээг үзүүлнэ.	<ul style="list-style-type: none"><li>Тасралтгүй, насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлнэ.</li><li>Амьжиргааны баталгаажих түвшнээс доош, эмзэг бүлгийн гэр бүлийн элсэгч, суралцагчдад дэмжлэг үзүүлнэ.</li><li>Суралцагчдын хүйсийн тэнцвэрт харьцааг эрх тэгш, зохистой хэмжээнд байлгана.</li><li>Багш, ажилтан, суралцагчдад шаардлагатай хэл, соёл, сэтгэл зүйн болон бусад дэмжлэгийг үзүүлнэ.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Төгсөгчдийн үргэлжлүүлэн суралцах байдал</li><li>Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхөөс суралцаж буй оюутны эзлэх хувь</li><li>Суралцагчдын хүйсийн харьцаа</li></ul>
4.3	Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дорвитой хувь нэмэр оруулна.	<ol style="list-style-type: none"><li>Нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлаар шинжлэх ухааны үндэслэлтэй сургалт, семинар явуулж зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.</li></ol>	<ul style="list-style-type: none"><li>Оюутны клуб, байгууллагын тоо</li></ul>

4.3	Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дорвитой хувь нэмэр оруулна.	<ol style="list-style-type: none"> <li>2. Багш, ажилтан, суралцагчдын хүмүүнлэгийн, сайн дурын санал санаачлагыг дэмжинэ.</li> <li>3. Сургууль – Суралцагч - Эцэг эх болон Сургууль - Ажил олгогч - Төгсөгчдийн гурван талт харилцааг дэмжинэ.</li> <li>4. Тулгамдсан асуудлаар бодлогын судалгааны салбар дундын төвийг байгуулж хөгжүүлэх тинк танкуудыг төвлөрүүлнэ.</li> <li>5. Суралцагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх судалгаанд үндэслэсэн нэгдсэн бодлого гаргаж хэрэгжүүлнэ.</li> <li>6. Төгсөгчдийг хөдөө, орон нутагт ажиллаж хөдөлмөрлөхөд зуучилна.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Оюутны байрны багтаамж шинээр элсэгчдийг бүрэн хамруулах боломжтой байх,</li> <li>• Нийт орлогод эзлэх нийгмийн хариуцлагын зардлын хувь,</li> <li>• Сайн санааны тусламж</li> </ul>
4.4	Мэргэжлийн үйлчилгээ-ний хүртээмж, нийгмийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	<ol style="list-style-type: none"> <li>1. ЕБС-ийн сургалтын чанарыг сайжруулахад хамтарч ажиллана.</li> <li>2. Ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий бүтцийг байгуулж, хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой мэдээллийн санд холбогдоно.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Мэргэжлийн үйлчилгээний гэрээ,</li> <li>• Мэргэжлийн үйлчилгээний сэтгэл ханамжийн үнэлгээ</li> </ul>
4.4	Мэргэжлийн үйлчилгээний хүртээмж, нийгмийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	<ol style="list-style-type: none"> <li>3. Стандарт, норм, норматив, дүрэм, аргачлалыг ашиглах талаар ААН, иргэдэд зөвлөх Төрийн болон ТББ, ШУТИС-ийн хамтарсан мэргэжлийн үйлчилгээний дундын төв байгуулна.</li> <li>4. Бодлого, эрх зүйн зөвлөх үйлчилгээг хүргэх, бүртгэх, хамтран ажиллах дэд бүтцийг хөгжүүлж үнэлнэ.</li> <li>5. Олон улсын стандарт, норм нормативтай холбоотой мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.</li> </ol>	



## ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ – 5: ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧЛЭЛ

**Зорилго:** Хариуцлагатай, хурдацтай өөрчлөлтөд нийцэх өндөр бүтээмжийн төлөө ухаалаг менежментийг явуулна.

№	Зорилтууд	Хэрэгжүүлэх стратеги	Явцын хэмжих үзүүлэлт
5.1	Академик эрх чөлөөг дээдэлсэн засаглал, удирдлагын бүтцийг хөгжүүлнэ.	<ol style="list-style-type: none"><li>1. Төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд их сургуулийн оролцоог нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшил-их сургуулийн гурвалсан холбоог бэхжүүлэх лобби бүлэг ажиллуулна.</li><li>2. Академик эрх чөлөөний талаар эрх зүйн орчныг бүрдүүлэхэд санаачлагатай ажиллана.</li><li>3. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн, процессийн ре-инженеринг хийх нөхцөлтэй уялдсан цомхон, үр өгөөжтэй бүтэц бүрдүүлж, эрх мэдэл, үүрэг хариуцлагын хуваарилалтыг оновчилно.</li><li>4. Их сургуулийн бүх түвшинд байгууллагын үнэт зүйлс, соёл, ёс зүйг төлөвшүүлнэ.</li><li>5. Шийдвэр гаргалтыг шуурхай болгох, мэдээллийн хүртээмж, ил тод байдал, хамтын оролцоог дээшлүүлэх зорилгоор их сургуулийн бүхий л үйл ажиллагаанд цахим засаглалын тогтолцоог нэвтрүүлнэ</li></ol>	<ul style="list-style-type: none"><li>• Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн түвшин,</li><li>• Хөндлөнгийн хяналт, үнэлгээний түвшин,</li><li>• Орлогын үр ашиг,</li><li>• Багш, ажилтны харьцаа,</li><li>• Шийдвэр гаргах хурд,</li><li>• Шийдвэр гаргахад сонирхогч талуудын оролцоог хангасан байдал,</li></ul>



5.2	Санхүүжилтийн олон талт эх үүсвэрийг бий болгоно.	<ol style="list-style-type: none"> <li>1. Улсын төсвийн санхүүжилтийн дэмжлэгийг нэмэгдүүлнэ.</li> <li>2. Үйл ажиллагааны орлогоор хөрөнгө оруулалт хийх эрх зүйн зохицуулалт бий болгоно.</li> <li>3. Төгсөгч, хувь хүн, хувийн хэвшил, олон улсын, төрийн бус байгууллагын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана.</li> <li>4. Их сургуульд түшиглэсэн эндаумент сан байгуулна.</li> <li>5. Зардлын уян хатан менежментийн систем нэвтрүүлж, сайжруулна.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүжилтийн өсөлт (эх үүсвэрээр),</li> <li>• Хандив, тусламж, тэтгэлэг, дэмжлэгийн өсөлт,</li> <li>• Санхүүгийн бие даасан байдал,</li> <li>• Нийт орлогод сургалтын төлбөрийн эзлэх хувь,</li> <li>• Эндаумент сангийн өсөлт</li> </ul>
5.3	Судалгааны их сургууль болох процессын ре-инженеринг хийнэ.	<ol style="list-style-type: none"> <li>1. Өнөөгийн процесст дүн шинжилгээ хийж, процессийн ре-инженеринг хийх бэлтгэл ажлыг хангана.</li> <li>2. Харилцан уялдаатай, PDCA зарчмаар бодлогын баримт бичгүүд, дүрэм, журмуудыг шинэчилж, системийн хандлагыг нэвтрүүлнэ.</li> <li>3. Баримт, нотолгоонд суурилсан засаглалын хяналт, үнэлгээ, сайжруулалт хийнэ.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Их сургуулийн үр ашиг,</li> <li>• Эрсдэлийн үзүүлэлт,</li> <li>• Чанарын үзүүлэлт,</li> <li>• Дүрэм, журмын шинэчлэгдсэн хувь</li> </ul>
5.4	Өөрчлөлт шинэчлэлтэд зохицох авьяас, ур чадвар бүхий хүний нөөцийг төвлөрүүлнэ.	<ol style="list-style-type: none"> <li>1. Дэлхийн судалгааны их сургуулийн жишигт нийцүүлж хүний нөөцийн төлөвлөлтийг хийнэ.</li> <li>2. Үйл ажиллагааг үр ашигтай хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлж, хүртээмжтэй сонгон шалгаруулалт явуулна.</li> <li>3. Хүний нөөцийн бизнесийн, англи хэлний, мэдээллийн технологийн болон мэргэжлийн (BEIT+P) ур чадварыг тодорхойлон үнэлж, тасралтгүй дээшлүүлнэ.</li> <li>4. Гүйцэтгэл, чадамжид суурилсан үнэлгээ, цалин урамшуулал, карьер хөгжлийн оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш, ажилтны харьцаа,</li> <li>• Чадамжийн түвшин,</li> <li>• Чадварлаг ажилтны тогтвортой ажилласан жил,</li> <li>• Хүний нөөцийн сэтгэл ханамжийн үнэлгээ,</li> <li>• Цалин, урамшууллын бодит өсөлтийн хувь,</li> </ul>



5.5	Ажиллах, суралцах, судалгаа хийхэд тохиромжтой орчин, дэд бүтцийг бүрдүүлж, хэвийн байлгана.	<ol style="list-style-type: none"><li>1. Ажиллах, суралцах, судалгаа хийх, үйлчилгээ үзүүлэх орчин, дэд бүтцийг сайжруулж, ашиглалтын менежментийг сайжруулна.</li><li>2. Удирдлагын мэдээллийн системийг процессийн ре-инженерингтэй уялдуулан загварыг тодорхойлж, боловсруулна.</li><li>3. Бусад мэдээллийн системүүдийг улам боловсронгуй болгож цогцоор нь хөгжүүлж, нэвтрүүлнэ.</li><li>4. Мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалтыг хангана.</li></ol>	<ul style="list-style-type: none"><li>• Сургуулийн барилга ашиглалтын үзүүлэлт (<i>үндсэн анги танхим: дэмжлэгийн анги танхим: судалгааны лабораторийн эзэмшлийн талбай</i>),</li><li>• Өгөгдөл, мэдээллийн сан хөмрөг,</li><li>• Цахим орчин дахь хандалтын тоо,</li><li>• Цаасны хэрэглээний хувь,</li><li>• Мэдээллийн ил тод байдал</li></ul>
5.6	Чанарыг тасралтгүй үнэлж, сайжруулах тогтолцоог бүрдүүлнэ.	<ol style="list-style-type: none"><li>1. Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэн, баталгаажуулж, тасралтгүй сайжруулна.</li><li>2. Оролцогч талуудын сэтгэл ханамжийн үнэлгээг байнга хийж, үр дүнг дээшлүүлнэ.</li><li>3. Байгууллагын хэмжээнд чанарын соёлыг түгээх, сайжруулалтын арга хэрэгслүүдийг хэрэгжүүлнэ.</li><li>4. Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлж, хэрэгжүүлнэ.</li><li>5. Хүн-байгальд ээлтэй шинэ стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэн, баталгаажуулна.</li></ol>	<ul style="list-style-type: none"><li>• Сонирхогч талуудын сэтгэл ханамжийн түвшин,</li><li>• Гомдлын тоо,</li><li>• ISO стандартын гэрчилгээ, түүний хүчинтэй байдал</li></ul>

5.7	Харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	<ol style="list-style-type: none"> <li>1. Төр-бизнес-их сургуулийн хамтын ажиллагааг хөгжүүлэх цахим платформийг хөгжүүлж, байнгын хэрэглээнд оруулна.</li> <li>2. Их сургуулийн хамтын ажиллагааны хүртээмжийг дээшлүүлж, гүйцэтгэлийн эргэх холбоог хангаж, бүтээмж, үр нөлөөг дээшлүүлнэ.</li> <li>3. Дотоод хамтын ажиллагааг нэмэгдүүлж, мэдлэг туршлагаа нээлттэй солилцох нөхцөл бүрдүүлж, ашиг сонирхлын зөрчилгүй байлгана.</li> <li>4. Төгсөгч, дэмжигчдийн холбоо, бусад ижил төрлийн үйл ажиллагаатай байгууллагын уялдааг бэхжүүлнэ.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Хамтын ажиллагаатай дотоод, гадаадын байгууллага, сургууль,</li> <li>• Түншлэлийн гэрээ, түүний биелэлт</li> </ul>
5.8	ШУТИС-ийн олон улсын өрсөлдөх чадвар, нэр хүндийг өсгөнө.	<ol style="list-style-type: none"> <li>1. Суралцагчдад олон улсын хэмжээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцох, хувь нэмэр оруулах хүсэл тэмүүлэл суулгана.</li> <li>2. Гадаад, дотоод оюутнууд харилцан туслалцах, мэдлэг, туршлага, соёлоо хуваалцах боломжийг бүрдүүлж, тоог нэмэгдүүлнэ.</li> <li>3. Гадаадын шилдэг их дээд сургуулиудтай стратегийн түншлэлийг хөгжүүлж, сургалт, судалгааны чанар, хамрах хүрээ, үр нөлөөг дээшлүүлнэ.</li> <li>4. Олон улсын солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.</li> <li>5. Олон улсын дээд боловсролын мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагаагаа сайжруулж, гадаад зах зээл дээр ШУТИС брэндийн нэр хүндийг өсгөнө.</li> <li>6. Багш, судлаачдыг олон улсын хурал, семинар, форум, зөвлөгөөн, симпозиумд оролцох байдлыг дэмжинэ.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>• Академик тэтгэлгийн хэмжээ,</li> <li>• Гадаад суралцагчийн хувь,</li> <li>• Солилцоогоор ирсэн гадаад суралцагч,</li> <li>• Солилцоогоор гадаадад явуулсан суралцагч,</li> <li>• Хамтарсан хөтөлбөр</li> <li>• Олон улсын хурал, семинар, форум, зөвлөгөөн, симпозиумд оролцсон тоо, үр дүн</li> </ul>

# ҮНДСЭН ЗОРИЛГОД ХҮРЭХ ЗАМЫН ЗУРАГЛАЛ- КР1

ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	СТЧ №	СҮҮРЬ ТҮВШИН 2019	ХҮРЭХ ҮР ДҮН		
			2022	2025	2030
ГАДААД СУРАЛЦАГЧДЫН (ОЮУТАН СОЛИЛЦООГООР ИРСЭН ТОО ОРНО) НИЙТ СУРАЛЦАГЧИД ЭЗЛЭХ ХУВЬ	2,3,4	<0.2%	0.5%	2%	5%
ГАДААД БАГШИЙН ЭЗЛЭХ ХУВЬ	2,3,4	<0.02%	4%	9%	12%
НИЙТ ОРЛОГООС СУРАЛЦАГЧДАД ОЛГОСОН ТЭТГЭЛГИЙН ХУВЬ	1,2,3	<0.1%	0.1%	0.3%	0.4%
ГАДААД ХЭЛ ДЭЭР ЯВАГДАХ БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТОО	1,2,3	0	10	12	14
ДОКТОРЫН ЗЭРЭГТЭЙ БАГШИЙН ЭЗЛЭХ ХУВЬ	1,2	38%	47%	60%	70%
НЭГ БАГШИД ОНОГДОХ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ БҮТЭЭЛИЙН ТОО	1,2,3	0.6	2	5	7
ШУТИС-ИЙН ЭЗЭМШИЛТЭЙ ОЮУНЫ ӨМЧИЙН ТОО	2,3	12	150	300	500
ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСАД ИДЭВХТЭЙ ПАТЕНТИЙН ТОО	2,3	3	10	30	50
ЛИЦЕНЗИЙН ГЭРЭЭНИЙ ТОО	3	0	2	6	10
ГАРААНЫ БИЗНЕСИЙН ТОО	3	2	5	15	30
НИЙТ ОРЛОГОД СУДАЛГАА, ИННОВАЦИЙН ОРЛОГЫН ЭЗЛЭХ ХУВЬ	2,3	12%	25%	40%	60%
НИЙТ ЗАРДАЛД СУДАЛГАА, ИННОВАЦИД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ	2,3	8.2%	20%	30%	50%

ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	СТЧ №	СУУРЬ ТҮВШИН 2019	ХҮРЭХ ҮР ДҮН		
			2022	2025	2030
ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ (АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН)	5	-	%	%	%
ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ ГАДААДЫН ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН ТОО (ЧАНСААГААР ОЛОН УЛСАД ЭХНИЙ 500-Д БАЙХ)	5	<28	40	50	65%
СОНИРХОГЧ ТАЛУУД (ОЮУТАН, ГАДААД ОЮУТАН, БАГШ, ТӨГСӨГЧ, ЭЦЭГ ЭХ, АЖИЛ ОЛГОГЧ)-ЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН	1-5	-	3.0<	4.0<	4.5<
БАКАЛАВР БА МАГИСТР, ДОКТОР ОЮУТНЫ ТООНЫ ХАРЬЦАА	1,2	9:1	9:2	9:4	9:6
ТӨГСӨГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ХУВЬ	1,2,3	<40%	50%	60%	65%
БАГШ, СУРАЛЦАГЧИЙН ТООНЫ ХАРЬЦАА	1,2,3,5	1:16	1:15	1:14	1:13
АМЬЖИРГААНЫ ТҮВШНЭЭС ДООГУУР ОРЛОГОЙ ӨРХӨӨС СУРАЛЦАЖ БҮЙ ОЮУТНЫ ЭЗЛЭХ ХУВЬ	4	3%	4%	5%	6%
ОЮУТНЫ БАЙРНЫ БАГТААМЖ НЬ ШИНЭЭР ЭЛСЭГЧИЙН ТООТОЙ ТЭНЦҮҮ БАЙХААР ТООЦОЖ ХУВИЛАХ	4,5	24.5%	30%	40%	50%









